



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт судалгааны хүрээлэнгийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

АУДИТЫН КОД: САГ-2026/274/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.</p> <hr/> <p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: А.Цогбаяр Утас: 260512 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn Аудитор: Д.Номингуа Утас: 261628 Цахим хаяг: nominguad@audit.gov.mn “ЦЭБЭ Консалтинг аудит” ХХК-ийн захирал: Д.Энхбаатар Утас: 77114235 Цахим хаяг: audit@tsebeconsulting.mn</p>
--	---

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан	12
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	16
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	17
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	18
4. Аудитын тайлан	22
4.1 Ерөнхий зүйл	22
4.2 Материаллаг байдал	22
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	23
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	26
5. Аудитын илрүүлэлт	26
5.1 Зөвлөмж	24
5.2 Төлбөрийн акт.....	26
5.3 Албан шаардлага.....	28
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	29

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/394
танай _____-ны № _____-т

ХҮН АМ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН СУРГАЛТ, СУДАЛГААНЫ
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
З.ЭНХБОЛД ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 879,946.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан 497,309.1 мянган төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээг хийгээгүй;
- Ажилтны ажлын байрны тодорхойлолтод ажил үүргийг орлон гүйцэтгэх үүрэгтэй ажилтнуудад ажил хавсран гүйцэтгэсний нийт 29,224.4 мянган төгрөгийн нэмэгдлийг хавтгайруулан олгосон;
- Бэлтгэн нийлүүлэгчийн төлбөрийг хугацаанд нь барагдуулаагүйгээс 11,596.7 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн зэрэг зөрчлүүд илэрсэн.

Дээрх зөрчлүүд нь УСНББОУС болон Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Засгийн газрын 2018 оны 382 тогтоол, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, Төрийн аудитын тухай хуулийн 23 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6 дахь заалтуудтай нийцээгүй бөгөөд

санхүүгийн тайлагналын "нийцсэн ба зохистой байх", "Үнэн ба зөв байх", "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 296,363.1 мянган төгрөгийн нэмэлт орлого бүрдүүлснээс 279,203.1 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 17,160.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн болон мэргэшлийн түвшнээ ахиулах иргэнийг ажил олгогчийн захиалгаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй мэргэжлээр ур чадвар олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулах хүрээнд нийт 4,080 иргэн танхимаар 85, цахимаар 15 сургалтад хамрагдаж, төгсөгчдийн чадамжийг тодорхойлох үнэлгээнд хийх хяналт хангалтгүй, үр дүн багатай байна.

Бусад асуудал

Тус хүрээлэнгийн 2025 оны "Гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан 3 зорилтын хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, жилийн эцсийн байдлаар 88.0 хувьтай үнэлэгдсэн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт нь Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн 246 дугаар "Төсвийн байгууллагыг өөрчлөн байгуулах тухай" тогтоолоор Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн болж өөрчлөгдөж, ГБХНХЯ-ны сайдын 05 дугаар сарын 30-ны өдрийн А/126 дугаар тушаалаар бүтэц орон тоог 10.7 хувиар буюу 67 ажилтантайгаар бууруулж баталсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Балансын зүйл	Тодруулга	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		363,680,086.50	130,666,200.39
33	АВЛАГА	5	252,221,666.78	34,374,656.29
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		38,586.54	1,621,156.29
33101	Цалингийн авлага		-	1,566,202.36
33102	НДШ-ийн авлага		38,586.54	54,953.93
33300	Татаас санхүүжилтийн авлага		252,183,080.24	32,753,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6	111,458,419.72	96,291,544.10
35400	Хангамжийн материал		111,458,419.72	96,291,544.10
35410	Бичиг хэргийн материал		16,357,990.00	24,907,288.50
35420	Аж ахуйн материал		58,498.00	-
35430	Сэлбэг хэрэгсэл		310,000.00	-
35470	Бусад хангамжийн материал		94,731,931.72	71,384,255.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,584,074,176.23	1,569,651,036.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7	1,584,074,176.23	1,569,651,036.93
392	Биет хөрөнгө		1,562,524,242.89	1,552,318,203.55
39201	Барилга, байгууламж, орон сууц		1,413,098,075.21	1,413,098,075.21
39202	Хуримтлагдсан элэгдэл		(316,613,316.94)	(340,164,951.58)
39203	Авто тээврийн хэрэгсэл		58,733,333.33	58,733,333.33
39204	Хуримтлагдсан элэгдэл		(43,538,888.88)	(58,733,333.33)
39205	Машин тоног төхөөрөмж		675,650,604.04	930,593,384.04
39206	Хуримтлагдсан элэгдэл		(419,813,097.48)	(609,815,894.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил		302,511,356.18	302,511,356.18
39208	Хуримтлагдсан элэгдэл		(113,054,822.58)	(149,454,766.10)
39217	Номын фонд		5,551,000.00	5,551,000.00
393	Биет бус хөрөнгө		21,549,933.34	17,332,833.38
39301	Программ хангамж		13,950,701.79	13,950,701.79
39302	Хуримтлагдсан элэгдэл		(8,912,768.45)	(13,129,868.41)
39303	Бусад биет бус хөрөнгө		16,512,000.00	16,512,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (3=1+2)		<u>1,947,754,262.73</u>	<u>1,700,317,237.32</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		2,762,983.00	32,887,605.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9	2,762,983.00	32,887,605.00
413	Өглөг		2,762,983.00	32,887,605.00
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		2,762,983.00	32,887,605.00

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41310	Ажилчидтай холбогдсон өглөг		2,762,983.00	32,887,605.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН		1,944,991,279.73	1,667,429,632.32
51	Засгийн газрын хувь оролцоо		1,944,991,279.73	1,667,429,632.32
5120	Хуримтлагдсан үр дүн		1,944,991,279.73	1,667,429,632.32
51210	Өмнөх үеийн үр дүн		1,607,440,018.90	1,944,991,279.73
51220	Тайлант үеийн үр дүн		337,551,260.83	(277,561,647.41)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (6=4+5)		<u>1,947,754,262.73</u>	<u>1,700,317,237.32</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2	4,096,978,419.54	2,817,149,800.00
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО		447,241,057.54	2,817,149,800.00
120	Нийтлэг татварын бус орлого		447,241,057.54	173,644,300.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		147,964,000.00	90,423,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого		147,964,000.00	90,218,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		-	205,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө		299,277,057.54	83,220,800.00
122	Тусламжийн орлого		-	2,643,505,500.00
1221	Хандив тусламж / дотоод/		-	2,643,505,500.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого		-	2,616,485,500.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого		-	2,616,485,500.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		-	27,020,000.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		-	27,020,000.00
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,649,737,362.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		1,890,915,300.00	-

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,890,915,300.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,758,822,062.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажил хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,758,822,062.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3	3,757,541,982.24	3,094,711,447.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,757,541,982.24	3,094,711,447.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,730,707,338.41	2,740,307,477.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,628,821,639.39	1,877,529,629.41
210101	Үндсэн цалин		1,049,386,671.61	1,079,372,821.15
210102	Нэмэгдэл		235,176,303.59	276,624,945.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт		202,880,360.82	368,755,699.50
210104	Урамшуулал		141,378,303.37	143,494,163.04
210105	Гэрээт ажлын цалин		-	9,282,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		206,594,516.00	241,075,930.91
210201	Тэтгэврийн даатгал		133,584,263.00	155,915,077.89
210202	Тэтгэмжийн даатгал		18,252,700.00	21,878,514.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		9,126,200.00	10,946,811.15
210204	Ажилгүйдлийн даатгал		9,126,300.00	10,911,702.78
210205	Эрүүл мэндийн даатгал		36,505,053.00	41,423,825.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		18,980,849.62	80,744,362.96
210301	Гэрэл, цахилгаан		6,441,966.46	8,921,830.31
210302	Түлш, халаалт		10,932,524.28	12,314,931.46
210303	Цэвэр, бохир ус		1,606,358.88	43,349.74
210304	Байрны түрээс		-	59,464,251.45
2104	Хангамж, бараа материалын зардал		84,135,771.00	89,094,153.50
210401	Бичиг хэрэг		63,246,779.00	64,115,121.50
210402	Тээвэр, шатахуун		110,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		16,807,532.00	17,557,834.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		-	810,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		3,971,460.00	6,611,198.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		9,050,000.00	5,548,581.74
210601	Багаж техник хэрэгсэл		190,000.00	-
210604	Урсгал засвар		8,860,000.00	5,548,581.74
2107	Томилолт, зочны зардал		49,169,710.00	12,512,800.00
210702	Дотоод албан томилолт		48,389,710.00	12,512,800.00

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		780,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		8,643,152.00	12,150,662.24
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,272,900.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		5,000,000.00	5,000,000.24
210803	Даатгалын үйлчилгээ		89,100.00	172,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		69,752.00	517,456.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		22,000.00	-
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс		1,751,500.00	6,177,000.00
210807	Газрын төлбөр		93,900.00	284,206.00
210809	Улсын мэдээллийн маягтын зардал		344,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,725,311,700.40	421,651,356.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		25,109,757.00	61,666,937.26
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,524,793,797.06	90,618,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		175,408,146.34	269,365,919.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		26,834,643.83	354,403,970.09
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	302,108,943.09
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг		-	302,108,943.09
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	302,108,943.09
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	284,948,943.09
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал		-	17,160,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		11,092,000.00	52,295,027.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		11,092,000.00	52,295,027.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		15,742,643.83	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		6,370,343.15	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		9,372,300.68	-

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)		339,436,437.30	(277,561,647.41)
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		1,885,176.47	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		1,885,176.47	-
7	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI)=(IV-V)		(1,885,176.48)	205,000.00
6	НИЙТ ҮР ДҮН (VII)=(III+VI)		<u>337,551,260.83</u>	<u>(277,561,647.41)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Тодруулга	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН		3,870,235,167.68	2,983,044,580.24
12	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО		147,964,000.00	70,401,000.00
120	Нийтлэг татварын бус орлого		147,964,000.00	70,401,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого		147,964,000.00	70,401,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого		147,964,000.00	70,196,000.00
120042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		-	205,000.00
122	Тусламжийн орлого		-	2,912,848,580.24
1221	Хандив тусламж / дотоод/		-	2,912,848,580.24
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого		-	2,616,485,500.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого		-	2,616,485,500.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого		-	296,363,080.24
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		-	218,554,520.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		-	77,808,560.24
13	ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,722,271,167.68	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		1,890,915,300.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		1,890,915,300.00	-

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,831,355,867.68	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит этгээдээс авсан хандив, тусламж		1,831,355,867.68	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагаанаас бий болсон нэмэлт орлого		-	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)		3,847,320,767.68	2,810,470,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,847,320,767.68	2,810,470,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		3,568,303,043.61	2,447,466,029.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		<u>1,626,097,242.93</u>	<u>1,881,875,182.16</u>
210101	Үндсэн цалин		1,046,662,275.15	1,083,718,373.90
210102	Нэмэгдэл		235,176,303.59	276,624,945.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт		202,880,360.82	368,755,699.50
210104	Урамшуулал		141,378,303.37	143,494,163.04
210105	Гэрээт ажлын цалин		-	9,282,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		206,594,516.00	241,075,930.91
210201	Тэтгэврийн даатгал		133,584,263.00	155,915,077.89
210202	Тэтгэмжийн даатгал		18,252,700.00	21,878,514.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		9,126,200.00	10,946,811.15
210204	Ажилгүйдлийн даатгал		9,126,300.00	10,911,702.78
210205	Эрүүл мэндийн даатгал		36,505,053.00	41,423,825.09
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		18,980,849.62	80,744,362.96
210301	Гэрэл, цахилгаан		6,441,966.46	8,921,830.31
210302	Түлш, халаалт		10,932,524.28	12,314,931.46
210303	Цэвэр, бохир ус		1,606,358.88	43,349.74
210304	Байрны түрээс		-	59,464,251.45
2104	Хангамж, бараа материалын зардал		97,679,551.00	101,221,667.00
210401	Бичиг хэрэг		59,986,249.00	42,589,005.00
210402	Тээвэр, шатахуун		453,900.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		16,807,532.00	14,856,834.00
210404	Ном, хэвлэл		-	25,900,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		-	810,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		20,431,870.00	17,065,828.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		15,082,065.00	24,820,933.74
210601	Багаж, техник, хэрэгсэл		4,562,065.00	-

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210604	Урсгал засвар		10,520,000.00	24,820,933.74
2107	Томилолт, зочны зардал		49,169,710.00	12,512,800.00
210702	Дотоод албан томилолт		48,389,710.00	12,512,800.00
210803	Зочин төлөөлөгч хүлээн авах		780,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		13,843,152.00	12,307,662.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		1,272,900.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		5,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ		89,100.00	172,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		69,752.00	517,456.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,751,500.00	6,177,000.00
210807	Газрын төлбөр		93,900.00	284,206.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх		5,544,000.00	5,157,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,540,855,957.06	90,618,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		4,413,990.00	2,288,991.14
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,536,441,967.06	90,618,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		279,017,724.07	363,003,970.09
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		-	310,708,943.09
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг		-	310,708,943.09
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	310,708,943.09
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	260,590,443.09
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал		-	17,160,000.00
2131125	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	24,358,500.00
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал		-	8,600,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		11,092,000.00	52,295,027.00

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		11,092,000.00	52,295,027.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		267,925,724.07	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		6,370,343.15	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		261,555,380.92	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		22,914,400.00	172,779,580.24
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		22,914,400.00	172,779,580.24
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		22,914,400.00	172,779,580.24
2200	Дотоод эх үүсвэрээр		22,914,400.00	172,779,580.24
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		22,914,400.00	172,779,580.24
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		(22,914,400.00)	(172,779,580.24)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,604,681,559.62	1,607,681,559.62
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,758,459.29	2,758,459.29
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,607,440,018.90	1,607,440,018.90
Тайлант үеийн үр дүн	337,551,260.83	337,551,260.83
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,944,991,279.73	1,944,991,279.73
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,944,991,279.73	1,944,991,279.73
Тайлант үеийн үр дүн	(277,561,647.41)	(277,561,647.41)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,667,429,632.32	1,667,429,632.32

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,674,782,000.00	2,426,091,056.91	(248,690,943.09)	90.7
12	Татварын бус орлого	2,674,782,000.00	2,426,091,056.91	(248,690,943.09)	90.7
120	Нийтлэг татварын бус орлого	46,042,500.00	70,196,000.00	24,153,500.00	152.5
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	46,042,500.00	70,196,000.00	24,153,500.00	152.5
122	Тусламжийн орлого	2,628,739,500.00	2,355,895,056.91	(272,844,443.09)	89.6
122005	Төсвөөс санхүүжих	2,628,739,500.00	2,355,895,056.91	(272,844,443.09)	89.6
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,674,782,000.00	2,401,937,556.91	(272,844,443.09)	89.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,674,782,000.00	2,401,937,556.91	(272,844,443.09)	89.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,622,486,000.00	2,349,642,529.91	(272,843,470.09)	89.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,095,328,400.00	1,872,593,182.16	(222,735,217.84)	89.4
210101	Үндсэн цалин	1,179,495,800.00	1,083,718,373.90	(95,777,426.10)	91.9
210102	Нэмэгдэл	369,908,800.00	276,624,945.72	(93,283,854.28)	74.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	336,644,200.00	368,755,699.50	32,111,490.50	109.5
210104	Урамшуулал	209,279,600.00	143,494,163.04	(65,785,436.96)	68.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	272,501,700.00	241,075,930.91	(31,425,769.09)	88.5
210201	Тэтгэврийн даатгал	184,858,100.00	155,915,077.89	(28,943,022.11)	84.3
210202	Тэтгэмжийн даатгал	21,909,300.00	21,878,514.00	(30,786.00)	99.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,953,100.00	10,946,811.15	(9,488.85)	99.9
210204	Ажилгүйдлийн даатгал	10,953,100.00	10,911,702.78	(41,397.22)	99.6
210205	Эрүүл мэндийн даатгал	43,824,900.00	41,423,825.09	(2,401,074.91)	94.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,895,300.00	80,744,362.96	(8,150,937.04)	90.8
210301	Гэрэл, цахилгаан	13,798,900.00	8,921,830.31	(4,877,069.69)	64.7
210302	Түлш, халаалт	9,914,900.00	12,314,931.46	2,400,031.46	124.2
210303	Цэвэр, бохир ус	2,943,500.00	43,349.74	(2,900,150.26)	1.5
210304	Байрны түрээс	62,238,000.00	59,464,251.45	(2,773,748.55)	95.5
2104	Хангамж, бараа материалын зардал	81,400,600.00	77,019,667.00	(4,380,933.00)	94.6
210401	Бичиг хэрэг	46,955,800.00	42,589,005.00	(4,366,795.00)	90.7
210402	Тээвэр, шатахуун	1,033,300.00	-	(1,033,300.00)	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,166,500.00	14,856,834.00	(1,309,666.00)	91.9

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,039,700.00	810,000.00	(229,700.00)	77.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,205,300.00	18,763,828.00	2,558,528.00	115.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,427,500.00	48,419,433.74	(8,066.26)	99.9
210601	Багаж техник хэрэглэл	23,598,500.00	23,598,500.00	-	100.0
210604	Урсгал засвар	24,829,000.00	24,820,933.74	(8,066.26)	99.9
2107	Томилолт зочны зардал	12,512,800.00	12,512,800.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	12,512,800.00	12,512,800.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,450,200.00	12,307,662.00	(5,642,538.00)	66.7
210801	Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	500,000.00	-	(500,000.00)	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,510,900.00	-	(2,510,900.00)	-
210803	Даатгалын үйлчилгээ	923,600.00	172,000.00	(751,600.00)	18.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	517,500.00	517,456.00	(44.00)	99.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	136,300.00	-	(136,300.00)	-
210806	Мэдээллийн технологийн зардал	8,415,300.00	6,177,000.00	(2,238,300.00)	73.4
210807	Нийтлэг үйлчилгээний төлбөр хураамж	284,500.00	284,206.00	(294.00)	99.9
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,162,100.00	5,157,000.00	(5,100.00)	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,969,500.00	4,969,491.14	(8.86)	99.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,289,000.00	2,288,991.14	(8.86)	99.9
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	2,680,500.00	2,680,500.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52,296,000.00	52,295,927.00	(73.00)	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,296,000.00	52,295,927.00	(73.00)	99.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	52,296,000.00	52,295,927.00	(73.00)	99.9
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	24,153,500.00	24,153,500.00	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	(24,153,500.00)	(24,153,500.00)	-

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	67	67	-	100.0
620001	Удирдах ажилтан	3	3	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	60	60	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4	4	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	67	67	-	100.0
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч	42	42	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	25	25	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	296,363,080.24
12	Татварын бус орлого	-	296,363,080.24
122	Тусламжийн орлого	-	296,363,080.24
1221	Хандив тусламж / дотоод/	-	296,363,080.24
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	296,363,080.24
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	218,554,520.00
350016	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	77,808,560.24
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	123,120,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	123,120,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	123,120,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	9,282,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	9,282,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	25,900,000.00
210404	Ном, хэвлэл	-	25,900,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	87,938,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	-	87,938,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		173,243,080.24
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		(173,243,080.24)

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн нь хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны судалгаа, шинжилгээ, хөдөлмөрийн зах зээлийн дунд болон урт хугацааны таамаглал боловсруулах, нийгмийн хамгаалал, хүн амын хөгжлийн бодлогын судалгаа шинжилгээ хэтийн болон ойрын төлөвлөлт, тооцоолол хийх, бодлогын зөвлөмж боловсруулах, гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, салбарын их өгөгдөл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, мэдээллийн зохистой ашиглалтыг хангах, их өгөгдөлд суурилсан бодлогын шинжилгээ хийх, бодлогын зөвлөмж боловсруулах, үндэсний ажил мэргэжлийн ангилал тодорхойлолт, стандарт боловсруулах, батлуулах, мэргэшлийн уялдааг хангах, зохицуулах үндсэн чиг үүрэг бүхий сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тус хүрээлэн нь эрхэм зорилгоо “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хүний нөөцийн чадавх, үндэсний ажил мэргэжлийн ангилал, стандартыг олон улсын түвшинд нийцүүлэн хөгжүүлэх, их өгөгдөл, нотолгоонд суурилсан бодлогын судалгаа, шинжилгээний тэргүүлэх эрдэм шинжилгээний байгууллага байна.” гэж тодорхойлсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Татварын багц хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, тогтоомжид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 Аж ахуйн нэгж, байгууллага нь "Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно."
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:” дараах заалтууд нэмсэн. Үүнд: тус хуулийн 15.1.8 “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах”, 15.2.7 “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх.”
- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх

хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”
- Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн “Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай” 05 дугаар албан даалгавар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хөдөлмөр, нийгэм хамгааллын яамны Төрийн нарын бичгийн даргын 2017 оны А/270 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй, шинээр гарсан хууль тогтоомж, дүрэм, журмын өөрчлөлтийг тусгах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 247,437.0 мянган төгрөгөөр буюу 12.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	252,221.7	34,374.7	(217,847.0)
Бараа материал	111,458.4	96,291.5	(15,166.9)
Үндсэн хөрөнгө	1,584,074.2	1,569,651.0	(14,423.1)
Нийт хөрөнгө	1,947,754.3	1,700,317.2	(247,437.0)
Богино хугацаат өр төлбөр	2,763.0	32,887.6	30,124.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,944,991.3	1,667,429.6	(277,561.6)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,947,754.3	1,700,317.2	(247,437.0)

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Авлагын дансны үлдэгдэл 34,374.7 мянган төгрөг болж 217,847.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны татаас, санхүүжилтийн авлага барагдсанаас шалтгаалсан;
- Бараа материалын дансны үлдэгдэл 96,291.5 мянган төгрөг болж 15,166.9 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 112,978.7 мянган төгрөгийн бичгийн хэрэгсэл, аж ахуйн материал, хангамжийн материал худалдан авч, үйл ажиллагаанд 128,145.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,569,651.0 мянган төгрөг болж 14,423.1 мянган төгрөгөөр буурсан нь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/131 дугаар албан бичгээр 4 нэр төрлийн 65 ширхэг компьютер, принтер, таблет зэрэг нийт 83,220.8 мянган төгрөгийн хөрөнгийг нийлүүлж, 143 ширхэг тоног төхөөрөмжийг 171,722.0 мянган төгрөгөөр худалдан авсан, тайлант онд 269,365.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос шалтгаалсан;
- Богино хугацаат өр төлбөр өмнөх оноос 30,124.6 мянган төгрөгөөр нэмэгдэж 32,887.6 мянган төгрөг болсон нь бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх төлбөрийг цаг хугацаанд нь барагдуулаагүйтэй холбоотой;
- Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,667,429.6 мянган төгрөг болсон нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан.

Программ хангамжийн бүртгэл, тайлагналтай холбоотой судалгаа:

- Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн нь санхүүгийн үйл ажиллагаанд 3, урсгал үйл ажиллагаанд 6, нийт 821.0 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй 9 программ хангамжтай байна. Өнөөдрийн байдлаар студи мини болон эвлүүлгийн программыг ашиглаагүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн

5 дугаар зүйлийн 5.1-т заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус хүрээлэнгийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,555,401.7 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны орлогоор 180,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, зардлыг 2,735,401.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 50,095.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, улсын төсвөөс 2,388,632.2 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 396,964.5 мянган төгрөг, нийт урсгал үйл ажиллагааны зардлын төсвийг 2,785,496.8 мянган төгрөгөөр баталж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01/52 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Батлагдсан төсвийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгаж оновчтой болгох, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд туссан багш, эмч нараас бусад төрийн албан хаагчийн орон тоог 9.0 хувиар бууруулах арга хэмжээг 2025 оны төсвийн тодотголын хүрээнд эхлүүлэхээр шийдвэрлэж холбогдох зардлыг 2025 оны 7 дугаар сард тодотголоор 110,714.8 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 2,628,739.5 мянган төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 46,042.5 мянган төгрөг, нийт 2,674,782.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,628,739.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 46,042.5 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлого бүрдүүлэхээс гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,355,895.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоос 70,196.0 мянган төгрөгийг тус тус бүрдүүлж, 2,401,937.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 284,744.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,401,937.6 мянган төгрөг буюу 89.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 272,844.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
72102 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	2,727,078.0	2,478,386.1	(248,691.9)	90.9
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	2,674,782.0	2,426,091.1	(248,690.9)	90.7
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	52,296.0	52,295.0	1.0	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

- Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн батлагдсан орон тоог ГБХНХЯ-ны сайдын 05 дугаар сарын 30-ны өдрийн А/126 дугаар тушаалаар 10.7 хувиар бууруулж, 67 ажилтантай болгож цомхотгол хийсэн;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны Б/01 тушаалаар ажилтанд 1 өдрийн хоолны хөнгөлөлт 29.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлт 3.0 мянган төгрөгөөр тооцож олгохоор баталсан;
- Унаа хоолны хөнгөлөлтийн зардлын гүйцэтгэл 368,755.7 мянган төгрөг буюу 109.5 хувьтай байгаа нь зардлын төсвийг 32,111.5 мянган төгрөгөөр илүү зарцуулсан;
- Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнд гадаад томилолтын зардал гараагүй;
- Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн захирлын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/34 дугаар тушаалаар 7 ажилтан Төрийн худалдан авах ажиллагааны АЗ сургалт, 03 дугаар сарын 26-ны өдрийн А/64 дугаар тушаалаар 3 ажилтан англи хэлний сургалтад тус тус хамрагдаж, нийт 2,644.5 мянган төгрөгийг төсөвлөгдсөн зардлын хэмжээнд зарцуулсан;
- Тус байгууллага нь тайлант онд Интерпресс ХХК-иар 19,800.0 мянган төгрөгийн сургалтын гарын авлага, Соёмбо принтинг ХХК-иар 20,720.4 мянган төгрөгийн чадамжийн гэрчилгээний хавтас хэвлүүлсэн.

Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 181/ШШ2024/03702 дугаар тогтоолоор хүрээлэнгийн захирлын 2023 оны Б/20 тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 22,504.0 мянган төгрөгийн цалингийн нөхөн олговор олгож, буруу шийдвэр гаргасан тухайн үеийн захирал нь ажлаас гарсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон 296,363.1 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлж, тоног төхөөрөмж, ном худалдан авахад 173,383.1 мянган төгрөг, гэрээт ажлын цалингийн зардалд 9,282.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардалд 87,938.0 мянган төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулалд 8,600.0 мянган төгрөг зарцуулж 17,160.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.3.1 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжсэн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих					
Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөр	2025.05.31-2025.08.29		Төслийн ажил хийгдэж дууссан	252,183.0	252,183.0
Дүн				252,183.0	252,183.0

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2023 оны 04 дүгээр тогтоолоор ажилгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн болон мэргэшлийн түвшнээ ахиулах иргэнийг ажил олгогчийн захиалгаар хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй мэргэжлээр ур чадвар олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулах, хөдөлмөр эрхлэлт, тогтвортой ажлын байрыг дэмжихэд чиглэсэн "Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөр"-ийг баталсан. Төсөл нь 2024 онд эхэлсэн боловч 2025 оны 5 дугаар сарын 31-нд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай 252,183.0 мянган төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан байна. Гэрээний нийт үнийн дүнгээс хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай компьютер, тоног төхөөрөмжийг 147,183.0 мянган төгрөгөөр худалдан авч, 105,000.0 мянган төгрөгөөр ур чадвар олгох сургалт зохион байгуулж, санхүүжилтийг бүрэн зарцуулсан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн нь тайлант онд 10 аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс 306,902.1 мянган төгрөгийн 56 нэр төрлийн 208 ширхэг тоног төхөөрөмж, бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа гүйцэтгэгчийг харьцуулалтын болон нээлттэй тендер сонгон шалгаруулах журмаар сонгон шалгаруулаагүй, шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Тус хүрээлэнгийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой нягтлан бодох бүртгэл хөтлөлт, ажиллагсдын цалин хөлс, нэмэгдлийг журмын хүрээнд олгох, үндсэн хөрөнгийн бүртгэлд тавих дотоод хяналтыг сайжруулах, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллахтай холбоотой асуудалд өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “ЦЭБЭ Консалтинг аудит” ХХК-ийн ахлах аудитор Г.Баянжаргал, аудитор Д.Мэндбаяр нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг, аудитын менежер Ж.Эрдэнэбилэг, захирал Д.Энхбаатар, Санхүүгийн аудитын газрын аудитор Д.Номингуа, аудитын менежер А.Цогбаяр, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “ЦЭБЭ Консалтинг аудит” ХХК-нд 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 17 дугаар албан бичгээр, хуулийн хугацаа 3 хоног хоцроож ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардлын 3,870,235.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 38,702.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хэмнэх боломжтой зардлуудыг хэмнэх дараах арга хэмжээ авч ажилласан байна. Үүнд: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тайлант онд цалин хөлс болон нэмэгдэл урамшууллыг 222,735.2 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 31,425.8 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчилд 22,504.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 18 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих тендер шалгаруулсан худалдан авах ажиллагааны 254,538.6 мянган төгрөгийн 6, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш нийт орлогын 2,948,912.8 мянган төгрөгийн 19, зарлагын 1,884,242.4 мянган төгрөгийн 65, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 2,634,386.4 мянган төгрөгийн 81 мэдээлэл, нийт мэдээлбэл зохих 7,722,080.2 мянган төгрөгийн 171 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 181/ШШ2024/03702 дугаар тогтоолоор хүрээлэнгийн захирлын 2023 оны Б/20 тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 22,504.0 мянган төгрөгийн цалингийн нөхөн олговор олгосныг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй, авлагаар бүртгээгүй байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-т “Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ.”, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө.”, 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох

бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шүүхийн тогтоолыг үндэслэн хүрээлэнгийн захирлын 2023 оны Б/20 дугаар тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд цалингийн нөхөн олговор олгосныг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллах.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, санхүүгийн тайлан, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, татварын бүртгэл, цалин хөлстэй холбоотой дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажуулсан. Завсрын аудитаар нийт 157,006.3 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илрүүлснээс 125,180.4 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 29,224.4 мянган төгрөгийн 1 зөрчлийг аудитын тайланд тусгаж, 2,601.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

- Тус байгууллага нь хөдөлмөр хөлс, түүнтэй адилтгах орлогыг Нийгмийн даатгалын байгууллагад 2025 оны 1-9 сарын байдлаар 68,889.5 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан.
- Үндсэн хөрөнгийн шинжтэй 33 нэр төрлийн 254 ширхэг 56,290.9 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байсныг тус тус залруулга хийлгэсэн.

Зөвлөмж:

- 2025 оны 1-9 сарын байдлаар нэмэгдэл цалинг 2,601.5 мянган төгрөгөөр дутуу тооцсон.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон нийт 2,841,188.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 10,584.5 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт, 2,155,766.9 мянган төгрөгийн 2 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага, 311,896.3 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 362,940.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өгсөн.

Аудитын шийдвэрийн хэрэгжилт дунджаар 74.3 хувьтай биелсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	4	10,584.5	4	2,474.5	76.3
Хариуцлага тооцох албан шаардлага	2	2,155,766.9	2	1,291,183.1	60.0
Албан шаардлага	3	311,896.3	3	270,414.1	86.7
Зөвлөмж	7	362,940.5	7	269,664.8	74.3
Нийт дүн	16	2,841,188.2	16	1,833,736.5	74.3

- Өмнөх оны аудитаар элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, холбогдох дээд байгууллагад хандан шийдвэрлэх, зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд үлдэх өртөггүй хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн байх тул Гүйцэтгэх удирдлага болон нягтлан бодогчид хариуцлага тооцох албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн болно.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудад анхаарлаа хандуулж аудитын горим, сорил хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналтай холбоотой шинэчлэн батлагдсан заавар журмуудын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг шинэчилсэн эсэх;
- Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу гэрээ байгуулсан өдрөөс эхлэн ажилтныг нийгмийн даатгалд албан журмаар даатгуулсан эсэх;
- Ажилтнуудад урамшуулал олгохдоо Захирлын тушаал шийдвэрийн үндэслэлийг хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа журмыг үндэслэн гаргасан эсэх;
- Бараа материалын дансанд бүртгэлтэй үндсэн хөрөнгийг зохих дансанд шилжүүлэн бүртгэсэн эсэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 25,043.6 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Тайлант онд 1,450.0 мянган төгрөгийн үнэ бүхий чихэвч камерыг худалдан авч бичиг хэргийн материалын дансанд бүртгэсэн;
- 2024 оны 2 сард худалдан авсан 16,512.0 мянган төгрөгийн олон үйлдэлт принтерийг биет бус хөрөнгөөр бүртгэсэн;
- Тайлант онд 16,512.0 мянган төгрөгийн үнэ бүхий олон үйлдэлт принтерт 6,054.4 мянган төгрөгийн элэгдүүлэлтийг хүлээн зөвшөөрч тооцоогүй;
- Өөрийн байрны цахилгааны төлбөрийн 411.2 мянган төгрөгийг түрээсийн зардлаас гаргасан;
- Сууц өмчлөгчдийн холбооны төлбөрт 616.0 мянган төгрөг илүү төлж, авлагаар бүртгээгүй.

Эдгээр алдаанууд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана", 20 дугаар

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 329 тогтоолын 1 дүгээр хавсралт "НББ-ийн Үнэн зөв байх "Санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэнэ", Тогтвортой байх "Нэг үеэс нөгөө үед зэрэгцүүлэх боломжтой байх үүднээс бүртгэлийн арга, сууриа тогтвортой баримтлах хэрэгтэй", гэж заасантай тус тус нийцэхгүй УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулгын 1.27, УСНББОУС-17 Үндсэн хөрөнгийн 17.42 дахь параграф болон санхүүгийн аудитын "Оршин байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитаар нийт 879,946.9 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд 4,789.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх 2 төлбөрийн акт тогтоож, 349,344.3 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх 4 албан шаардлага хүргүүлж, 28,504.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 зөвлөмж өгч, 497,309.1 мянган төгрөгийн зөрчилд эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан албан хаагчдад хариуцлага тооцуулах 2 албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн нийт 879,946.9 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 841,244.5 мянган төгрөгөөр их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

1. Илрүүлэлт:

Дотоод албан томилолтоор ажиллах хугацаанд нь 3 ажилтанд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлс 481.9 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилтнуудад илүү тооцож олгосон нийт 481.9 мянган төгрөгийг буруутай ажилтнаар төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

2. Илрүүлэлт:

"Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлт" судалгааг 2025 онд давтан гүйцэтгэсэн, Захирлын 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн А/115, А/117 дугаар 2 тушаалаар байгууллагын 6 ажилтанд 3, 4 саруудад ажилласан хоногийн илүү цаг тооцож 4,307.6 мянган төгрөгийг Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын "нэмэгдэл хөлс тооцох аргачлал"-ын 1 дэх заалт, "нэмэгдэл хөлс олгох" хэсгийн 3 дахь заалтыг зөрчиж олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2

² Хүний төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

дугаар хавсралтын 2 дахь хэсгийн 1-т "Нэмэгдэл хөлсийг төрийн албан хаагчийн ажилласан тухайн сарын цалин хөлсийг үндэслэн тодорхойлно.", 3 дахь хэсгийн 3-т "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү цагийн хөлсийг зөрүүтэй тооцож олгосныг буруутай ажилтнаар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Хариуцлага тооцох албан шаардлага

1. Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, тээврийн хэрэгсэл, программ хангамж зэрэг нийт 242 нэр төрлийн 497,309.1 мянган төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй, өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "...элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, ... эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын 19.1-т "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна.", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

2. Илрүүлэлт:

Өмнөх оны аудитаар тогтоосон 10,584.5 мянган төгрөгийн 4 төлбөрийн актаас 8,110.0 мянган төгрөг нь төлөгдөөгүй, төлбөр барагдуулах арга хэмжээг зохион байгуулж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 23 дугаар зүйл "Албан шаардлага, төлбөрийн актын биелэлтийг хангах", 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." гэж заасан байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн актыг хугацаанд нь хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, ажилдаа хариуцлагагүй хандсан, нягтлан бодогчид хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Албан шаардлага

1. Илрүүлэлт:

Тайлант оны эцэст ажилтнаас авах 1,621.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", Нягтлан бодох бүртгэл тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Илрүүлэлт:

Тайлант оны төлбөрийг хугацаанд төлж барагдуулаагүйгээс 11,596.6 мянган төгрөгийн өр үүсгэн, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэл тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, нэмж өр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Илрүүлэлт:

Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэлгүй, 306,902.1 мянган төгрөгийн өртөгтэй 56 нэр төрлийн бараа ажил үйлчилгээг шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.", Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4. Илрүүлэлт:

Тус байгууллага нь 2025 оны 1-9 саруудад албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан орлон гүйцэтгэх үүрэгтэй нийт 49 ажилтанд ажил хавсран гүйцэтгэсний 29,224.4 мянган төгрөгийн нэмэгдлийг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин урамшуулал олгох журмын 2 дугаар зүйлийн 2.1-т "Төрийн албаны тухай хуулийн 42.1-д заасан үндэслэлээр эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг 2-6 сар хүртэл хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид цалингийн зөрүүг олгоно.", 2.2-т "Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно.", Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6-д "Ажилтанд эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсний болон бусад нэмэгдэл хөлсний хэмжээг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг олгохдоо холбогдох хууль, журмыг баримтлаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.4 Зөвлөмж

1. Илрүүлэлт:

Захирлын 2025 оны Б/34 тушаалаар нэр бүхий 5 ажилтанд төсөвт тусгагдаагүй 6,000.0 мянган төгрөгийн буцалтгүй тэтгэмжийг Удирдах зөвлөлийн хурлын шийдвэргүйгээр олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах",

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 8.3.1-т "Ажилтнуудын нийгмийн асуудал /орон сууц, орон сууцны нөхцөлөө сайжруулах, гэр, хашаа байшин/-тай болоход санхүүгийн бодитой дэмжлэг, нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх ба Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Удирдах зөвлөлийн хурлын шийдвэргүйгээр олгосон зөрчлийг арилгах, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтыг мөрдөж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант онд 1,450.0 мянган төгрөгийн үнэ бүхий чихэвч камерыг худалдан авч бичиг хэргийн материалын дансанд бүртгэсэн.	1	1,450.0			1	1,450.0	1	1,450.0				
2024 оны 2 сард худалдан авсан 16,512.0 мянган төгрөгийн олон үйлдэлт принтерийг биет бус хөрөнгөөр бүртгэсэн.	1	16,512.0			1	16,512.0	1	16,512.0				
Тайлант онд 16,512.0 мянган төгрөгийн үнэ бүхий олон үйлдэлт принтерт 6,054.4 мянган төгрөгийн элэгдүүлэлтийг хүлээн зөвшөөрч тооцоогүй.	1	6,054.4			1	6,054.4	1	6,054.4				
Өөрийн байрны цахилгааны төлбөрийн 411.2 мянган төгрөгийг түрээсийн зардлаас гаргасан.	1	441.2			1	441.2	1	441.2				
Сууц өмчлөгчдийн холбооны төлбөрт 616.0 мянган төгрөг илүү төлж, авлагаар бүртгээгүй.	1	616.0			1	616.0	1	616.0				
Дүн	5	25,043.6			5	25,043.6	5	25,043.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, тээврийн хэрэгсэл, программ хангамж зэрэг нийт 242 нэр төрлийн 497,309.1 мянган төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй, өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.	1	497,309.1								1	497,309.1		
Тайлант оны эцэст ажилтнаас авах 1,621.2 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	1,621.2			1	1,621.2							
Тайлант оны төлбөрийг хугацаанд төлж барагдуулаагүйгээс 11,596.6 мянган төгрөгийн өр үүсгэн, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	11,596.6			1	11,596.6							
Өмнөх аудитаар тогтоосон 10,485.5 мянган төгрөгийн 4 төлбөрийн актаас 8,110.0 мянган төгрөг нь төлөгдөөгүй, төлбөр барагдуулах арга хэмжээг зохион байгуулж ажиллаагүй байна.	1	-								1	-		

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

"Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлт" судалгааг 2025 онд давтан гүйцэтгэсэн, Захирлын 2025 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр А/115, А/117 дугаар 2 тушаалуудаар байгууллагын 6 ажилтанд 3, 4 саруудад ажилласан хоногийн илүү цаг тооцон 4,307.6 мянган төгрөгийг Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын "нэмэгдэл хөлс тооцох аргачлал"-ын 1 дэх заалт, "нэмэгдэл хөлс олгох" хэсгийн 3 дахь заалтыг зөрчиж олгосон байна.	1	4,307.6	1	4,307.6								
Дотоод томилолтоор ажиллаж байх хугацаанд ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлсийг 3 ажилтанд 481.9 мянган төгрөгийг илүү тооцож олгосон	1	481.9	1	481.9								
Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэлгүй, 306,902.1 мянган төгрөгийн өртөгтэй 56 нэр төрлийн бараа ажил үйлчилгээг шууд худалдан авсан байна.	1	306,902.1			1	306,902.1						
Захирлын 2025 оны Б/34 тушаалаар нэр бүхий 5 ажилтанд төсөвт тусгагдаагүй 6,000.0 мянган төгрөгийн буцалтгүй тэтгэмжийг Удирдах зөвлөлийн хурлын шийдвэргүйгээр олгосон байна.	1	6,000.0					1	6,000.0				
Тус байгууллага нь 2025 оны 1-9 саруудад албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод	1	29,224.4			1	29,224.4						

Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

заагдсан орлон гүйцэтгэх үүрэгтэй нийт 49 ажилтанд ажил хавсран гүйцэтгэсний 29,224.4 мянган төгрөгийн нэмэгдлийг хавтгайруулан олгосон байна.												
Дүн	9	857,442.9	2	4,789.5	4	349,344.3	1	6,000.0	2	497,309.1		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн					
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
1	Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 181/ШШ2024/03702 дугаар тогтоолоор хүрээлэнгийн захирлын 2023 оны Б/20 тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд 22,504.0 мянган төгрөгийн цалингийн нөхөн олговор олгосныг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй, авлагаар бүртгээгүй байна.	1	22,504.0							1	22,504.0	
	Дүн	1	22,504.0							1	22,504.0	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 21/АО/50169

Улаанбаатар хот

САГ-2026/274/НА-СТА-ТЦЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд сургалт, бүртгэл мэдээллийн албаны арга зүйч /О.Болорчимэг/, загварчлал, системийн динамик өгөгдлийн статистик тооцоолол хариуцсан эрдэм шинжилгээний ажилтан /Б.Халиунаа/, үнэлгээ, баталгаажуулалт хариуцсан арга зүйч /Э.Ундрал/ нарт дотоод албан томилолтоор ажиллах хугацаанд нь томилолтын хоногийг хасаж тооцохгүйгээр хавсран гүйцэтгэсний нэмэгдэл хөлс нийт 481,873.00 /дөрвөн зуун наян нэгэн мянга найман зуун далан гурван/ төгрөгийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5 "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн", 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн нь ажилтнуудад илүү тооцож олгосон нийт 481,873.00 /дөрвөн зуун наян нэгэн мянга найман зуун далан гурван/ төгрөгийг, тооцоо бодсон нягтлан бодогч /Б.Пүрэвцэцэг/-ээр нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн Гүйцэтгэх удирдлагад хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Д.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 50/АО/5068

Улаанбаатар хот

СЭГ-2026/274/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлт" судалгааг 2025 онд давтан гүйцэтгэсэн, захирлын 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн А/115, А/117 дугаар тушаалуудыг үндэслэн байгууллагын 6 ажилтанд 3, 4 саруудад ажилласан хоногт илүү цаг тооцон 4,307,645.00 /дөрвөн сая гурван зуун долоон мянга зургаан зуун дөчин таван/ төгрөгийг Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын "нэмэгдэл хөлс тооцох аргачлал"-ын 1, "нэмэгдэл хөлс олгох" хэсгийн 3 дахь заалтыг зөрчиж олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дах хэсгийн 1-т "Нэмэгдэл хөлсийг төрийн албан хаагчийн ажилласан тухайн сарын цалин хөлсийг үндэслэн тодорхойлно.", 3 дахь хэсгийн 3-т "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-т "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн;" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэн нь илүү цагийн хөлсийг зөрүүтэй тооцож олгосон 4,307,645.00 /дөрвөн сая гурван зуун долоон мянга зургаан зуун дөчин таван/ төгрөгийг тооцоо бодсон нягтлан бодогч Б.Пүрэвцэцэг/-ээр нөхөн төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн Гүйцэтгэх удирдлагад хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Д.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 450/A0150169

Улаанбаатар хот

САГ-2026/274/НА-СТА-ТШЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, тээврийн хэрэгсэл, программ хангамж зэрэг нийт 242 нэр төрлийн 497,309,097.65 /дөрвөн зуун ерэн долоон сая гурван зуун есөн мянга ерэн долоон/ төгрөгийн үнийн дүн бүхий элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, дахин үнэлэх асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй, өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2-т "...элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, ... эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалын 19.1-т "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна.", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалын баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-77.Docx

1526180960

“Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага” хүргүүлнэ;” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн нягтлан бодогч /Б.Пүрэвцэцэг/-т хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн Гүйцэтгэх удирдлагад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Д.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 449/А0150169

Улаанбаатар хот

САГ-2026/274/НА-СТА-ТЦЗ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар тогтоосон 10,584,519.81 /арван сая таван зуун наян дөрвөн мянга таван зуун арван есөн/ төгрөгийн 4 төлбөрийн актаас 8,110,000.00 /найман сая нэг зуун арван/ төгрөг нь төлөгдөөгүй, төлбөр барагдуулах арга хэмжээг зохион байгуулж ажиллаагүй байна.


Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." гэж заасан байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т "Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ;" заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн нягтлан бодогч /Б.Пүрэвцэцэг/-т хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн Гүйцэтгэх удирдлагад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Д.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 446/A0150169

Улаанбаатар хот

САГ-2026/274/КА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эцэст ажилтнаас авах 1,621,156.29 /нэг сая зургаан зуун хорин нэгэн мянга нэг зуун тавин зургаан/ төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.8-д "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", Нягтлан бодох бүртгэл тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй;"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн Гүйцэтгэх удирдлага, Нягтлан бодогч /Б.Пүрэвцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР

Д.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 445/АД150169

Улаанбаатар хот

САГ-2026/274/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны төлбөрийг хугацаанд төлж барагдуулаагүйгээс 11,596,605.00 /арван нэгэн сая таван зуун ерэн зургаан мянга зургаан зуун таван/ төгрөгийн өр үүсгэн, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэл тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны авлага, өр төлбөрийн тооцоог ажил гүйлгээ гарахаас өмнө хянан баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгчтэй тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7 "авлага, өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй;"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн Гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч /Б.Пүрэвцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Д.ЭНХБААТАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 447/АД150169

Улаанбаатар хот

САГ-2026/274/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээгүй, нийт 306,902,140.00 /гурван зуун зургаан сая есөн зуун хоёр мянга нэг зуун дөчин/ төгрөгийн өртөгтэй 56 нэр төрлийн бараа ажил үйлчилгээг шууд худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно.", Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай." гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол,"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй, шууд худалдан авалт хийсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн Гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч /Б.Пүрэвцэцэг/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

(Handwritten signature)

Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Д.ЭНХБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z. Alban Shaardlaga\2026\0125 SAG-77.Docx

1526180955



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 448/A0150169

Улаанбаатар хот

САГ-2026/274/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь 2025 оны 1-9 саруудад албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан орлон гүйцэтгэх үүрэгтэй нийт 49 ажилтанд ажил хавсран гүйцэтгэсний 29,224,422.00 /хорин есөн сая хоёр зуун хорин дөрвөн мянга дөрвөн зуун хорин хоёр/ төгрөгийн нэмэгдлийг хавтгайруулан олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох."; Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин урамшуулал олгох журмын 2 дугаар зүйлийн 2.1-т "Төрийн албаны тухай хуулийн 42.1-т заасан үндэслэлээр эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг 2-6 сар хүртэл хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид цалингийн зөрүүг олгоно."; 2.2-т "Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно." Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6 "Ажилтанд эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй нэмэлт ажил үүрэг гүйцэтгэсний болон бусад нэмэгдэл хөлсний хэмжээг хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр тогтооно." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал;"-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг олгохдоо холбогдох хууль, журмыг баримтлаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, судалгааны хүрээлэнгийн Гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч /Б.Пүрэвцэцэг/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ЦЭБЭ КОНСАЛТИНГ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
А.ЦОГБАЯР
Д.ЭНХБААТАР